



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 437

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, 10 нэрийн, нийт 127,416,780.00 (нэг зуун хорин долоон сая дөрвөн зуун арван зургаан мянга долоон зуун наян) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Соёлын яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг, "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Ичинхорлоо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001456

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 437
дугаар тогтоолын хавсралт

"ДБУЭГ" ТӨҮГ-ын балансаас Соёлын яамны үндсэн хөрөнгийн дансанд
балансад шилжүүлэн бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Марк	Тоо шир хэг	Нэгжийн үнэ (төгрөгөөр)	Хөрөнгийн үнэ (төгрөгөөр)
1	Хурлын HD камер	HD Videoconference Camera /Black	2	9,400,440.00	18,800,880.0
2	Дэлгэцтэй хурал дараглагчийн микрофон	New Generation Paperless Multimedia Congress Terminal	3	8,761,480.00	26,284,440.0
3	Микрофоны хөл	HCS-5300TZJ2	2	104,300.00	208,600.0
4	Микрофоны урд хошуу	Stem Microphone	10	3,500.00	35,000.0
5	Чанга яригч	linear array speaker	6	601,750.00	3,610,500.0
6	Тайзны чанга яригч	monitor and apron stage speakers	3	230,000.00	690,000.0
7	Зурагт	19" LCD	2	130,000.00	260,000.0
8	Орчуулагчийн кабин	Interpreter Booth	1	35,000,000.00	35,000,000.0
9	кабель	coaxial cable	3	9,120.00	27,360.0
10	Тайз /Хөнгөнцагаан		200	212,500.00	42,500,000.0
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		232 (хоёр зуун гучин хоёр)		127,416,780.00 (нэг зуун хорин долоон сая дөрвөн зуун арван зургаан мянга долоон зуун наян)